



ШИНЭ НОМЫН МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Издательство "Горная книга-Монголия"
судалгааны танхимын нээлт

Хаан банкны нэрэмжит Эрдэм шинжилгээний
уншлагын танхимын нээлт

"Номын сан-Шахим шийдэл"

"Номын сангийн програм хангамжийн
авиглаалт"

Дэлхийн томоохон номын сангууд цуврал
/Оросын үндэсний номын сан/

2010/01-03 №01(13)

2010/01-03 №01(13)

Редактор: Ч.Гульнар

Эмхэтгэсэн: О.Ариунжаргал
Ж.Баатарсүрэн

Хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,
8-р хороо Шинжлэх Ухаан Технологийн төв номын сан
Утас: 314029, 77212224, 324590-1026, 1027
Майл: Library@must.edu.mn

А Г У У Л Г А

ШИНЭ НОМЫН МЭДЭЭ	
ШУТтөв номын сан	02
КТМС-ийн номын сан	36
МИС-ийн номын сан	40
МХТС-ийн номын сан	47
ҮТДС-ийн номын сан	54
<hr/>	
ИЗДАТЕЛЬСТВО “ГОРНАЯ КНИГА-МОНГОЛИЯ” СУДАЛГААНЫ ТАНХИМЫН НЭЭЛТ	64
<hr/>	
ХААН БАНКНЫ НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ УНШЛАГЫН ТАНХИМЫН НЭЭЛТ	65
<hr/>	
“НОМЫН САН-ЦАХИМ ШИЙДЭЛ” СУРГАЛТ	66
<hr/>	
“НОМЫН САНГИЙН ПРОГРАМ ХАНГАМЖИЙН АШИГЛАЛТ” СЭДЭВТ СУРГАЛТ БОЛЛОО	67
<hr/>	
ШУТТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНУУДАД СУРГАЛТ ЯВУУЛЛАА	67
<hr/>	
НОМ ХАНДИВЛАВ	68
<hr/>	
ДЭЛХИЙН ТОМООХОН НОМЫН САНГУУД ЦУВРАЛ /Оросын үндэсний номын сан/	68
<hr/>	
ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН НҮҮР ЦАРАЙ НОМЫН САНГААСАА ХАРАГДДАГ	69
<hr/>	
ЧОНЫУКЫН ИХ СУРГУУЛИЙН ДИЖИТАЛ НОМЫН САНТАЙ ТАНИЛЦАВ	71
<hr/>	
ЗААВАЛ УНШИХ 100 НОМЫН ЖАГСААЛТ	72



Шинжлэх Ухаан Технологийн төв номын сангийн шинэ номын мэдээ

Шинжлэх Ухаан Технологийн төв номын санд 2010 оны 01-03 сард хүлээн авсан шинэ номын мэдээ

ТЕХНИК, ТЕХНОЛОГИ



МОНГОЛЫН ГЕОЛОГИ БА АШИГТ МАЛТМАЛ

Зохиогч: Ж.Бямба
Литосферийн плитийн тектоник
Боть: IV

Он: 2009
Хот: УБ
Хэвлэлийн газар:
Соёмбо принтинг

Хуудас: 487
ISBN: 978-99929-4-465-X

Монголын нутаг дэвсгэрийн дүүрэгчлэлийг плиттектоникийн үзэл баримтлалын үүднээс хийсэн. Дорнод Саян-Монгол Алтайн, Төв Монголын, Өмнөд Монголын хэмээх гурван томоохон атираат мужийг ялгасан. Тэдгээрийг хэлбэржүүлж байгаа эртний ба атираат суурийн болон эх газрын хөгжлийн стрүктүүдийг тодорхойлсон байна. Мөн Монголын нутаг дэвсгэрийн гүний тогтоц, идэвхтэй тектоникийг тодорхойлсон хамт палеопротерозойгоос өнөөг хүртэлх геодинамикийн явцуудын хувьслыг өгсөн болно.

Шатах ашигт малтмал

Боть: V
Хуудас: 390
ISBN: 978-99929-4-469-2

Нүүрс, шатаг занар, газрын тос судлагч, ашиглагч байгууллага, хүмүүст эдгээр ашигт малтмалын геологийн судалгааны материалыг эмхэтгэн толилуулах зорилгоор бичсэн болно. Шатах ашигт малтмалын геологи, чанар найрлагын судалгааны мэдээллийг нэгтгэн, тэдгээрийн гарал үүсэл, хувирлын өвөрмөц онцлогийг тайлбарлаж, хэтийн төлөвийг үнэлсэн.

Метал ашигт малтмал

Боть: VI
Хуудас: 349
ISBN: 978-99929-4-470-6



Шинжлэх Ухаан Технологийн төв номын сангийн шинэ номын мэдээ

Монгол нутаг дэвсгэрт геологичдийн олж илрүүлэн судалж шинжилсэн төмөрлөг хар металлууд, вольфрам-цагаан тугалга, зэс, хар тугалга-цайр, хөнгөн цагаан зэрэг өнгөт металлууд, ховор шороон элементүүдийн хүдэржилт, алт, мөнгө, платины эрхэм металууд ба ураны хүдрийн ордууд, тэдгээрийн хүдэржилтийн геологийн тогтоц, бүтэц, бүрэлдэхүүн, шинж чанар, гарал үүсэл, байгалийн зүй тогтлын талаар өгүүлсэн болно.

Метал бус ашигт малтмал

Боть: VII

Хуудас: 324

ISBN: 978-99929-4-472-2

Металл бус ашигт малтмалын тухай ерөнхий ойлголтыг өгөхийн хамт, орчин үед олон улсын хэмжээнд мөрдөж байгаа металл бус ашигт малтмалын гарал үүслийн болон хэрэглээний ангиллын талаар тайлбар хийсэн байна. Мөн Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд судлагдаж тогтоогдсон металл бус ашигт малтмалын орд, илрэлүүдийн гарал үүсэл, хүдрийн төрөл, чанар, нөөцийн үнэлгээний талаарх мэдээллийг нэгтгэн үзүүлсэн.

Гидрогеологи

Боть: VIII

Хуудас: 390

ISBN: 978-99929-4-468-4

Монголын гидрогеологийн судалгааны үүх түүх, газрын доорхи ус агуулагч үе, бүрдэл, бүс, хагарал, гидрогеологийн дүүрэгчлэл, систем, ай сав, олон жилийн цэвдэгт нутгийн газрын доорх ус, монгол нутгийн газрын доорхи усны нөөц баялаг, найрлага хэрэглээ ашиглал, зэргийг нэгтгэн баяжуулсан. Мөн Монгол орны зарим рашааны талаар мэдээ баримт орсон.

Уул уурхай: Технологи, Экологи, Стратеги

Зохиогч: П.Очирбат


Редактор: Ш.Баясгалан

Дэд гарчиг: Манай эрдэмтэд

Монгол орны эрдэс баялагийн салбарын тогтвортой хөгжлийн стратеги болон газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтыг экологитой холбон судалсан бүтээлүүдийг оруулсан. Ялангуяа улсын эдийн засгийн хөгжилд онцгой байр эзэлдэг алт, газрын тос, уран, зэс нүүрс зэрэг ашигт малтмалын олборлолт боловсруулалтын технологийн инновацийн асуудал голлох үүрэгтэй.



Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: ШУТИС.
ХҮСТ
Хуудас: 292
ISBN: 99929-3-040-3



Он: 2006 Хот: УБ
Хуудас: 455
ISBN: 978-99929-3-115-9

CATIA V5 CAD/CAM

Зохиогч: Д.Цолмонбаатар
Хянан тохиолдуулсан: Lee Kunwoo

Catia V5 програм хангамжийг ашиглан элдэв төрлийн эд ангийн дизайны эскиз гаргаж улмаар гурван хэмжээстэд байгуулах, түүний ажлын зураг төсөл боловсруулах, угсаргааны зангилаа хийх, боловсруулах арга технологийг сонгож симуляци хэрхэн хийх тухай тодорхой жишээ авч тайлбарлаж бичсэн болно.



Он: 2009, Хот: УБ
Хуудас: 128
ISBN: 978-99929-994-8-9

Гидрогеологийн шинжлэх ухаан Монголд, газар доорхи усны ашиглалт

Зохиогч: Н.Батсүх
Хянан тохиолдуулсан: Д.Энхбаяр

Гидрогеологийн шинжлэх ухааны хөгжил, ололт, амжилт, түүний дотор манай оронд хэрхэн хөгжсөн байгаа хийгээд хүн төрөлхтөн газар доорх усыг яаж ашигладаг талаар дэлгэрэнгүй өгүүлсэн. Монголын гидрогеологич эрдэмтдийн гидрогеологийн шинжэх ухаанд оруулсан хувь нэмрийг эрдэмтэн тус бүрээр үнэлж бичсэн болно.



Он: 2009, Хот: УБ
Хэвлэлийн газар:
Женерал принтинг
Хуудас: 246
ISBN: 99929-310-8-9

Газрын тосны салбарын экологи

Зохиогч: Ц.Алтанцэцэг, Ц.Багмид, Ж.Цэвээнжав,
П.Наранчимэг
Хянан тохиолдуулсан: Ж.Цэвээнжав, Ж.Багмид
Редактор: Э.Лхагвасүрэн

Газрын тосны салбарын экологи, байгаль хамгаалал хичээлийн стандарт, сургалтын хөтөлбөрийн дагуу бичигдсэн энэхүү сурах бичигт экологи, байгаль хамгааллын тухай ерөнхий ойлголтууд, үйлдвэрийн болон ГТС-ын экологийн асуудлуудыг товч авч үзсэн ба салбарын бүрэлдэхүүний албад, үйл ажиллагааны чиглэл бүрээр системчлэн бичиж, бохирдуулагч хаягдлуудын хэмжээг тодорхойлох, хяналт тавих аргууд болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлалыг тусгасан болно.

Барилга байгууламжийн геотектоникийн асуудлууд

Зохиогч: Д.Дашжамц

Дэд гарчиг: Эрдэм шинжилгээний бүтээлүүдийн эмхэтгэл

Барилга хот байгуулалтын хөгжлийн бодлогод судалгааны ажлын үр дүнг ашиглах, мэргэжилтэн бэлтгэх зэрэг нийтлэг асуудлаас эхлээд монгол оронд өргөн тархсан олон жилийн цэвдэг хөрсөнд барилга байгууламжийн зураг төсөл зохиох, хөрсний хөлдөлтийн овойлтын үед үүсэх хүчдэл, хэв гажилтыг тодорхойлох, суумтгай хөрсний физик механик шинж чанарын судалгааны асуудлуудаас гадна, авто замын шороон далан, хаалт зэрэг инженерийн байгууламжийг төсөллөх, барьж байгуулах, ашиглахтай холбоотой өргөн хүрээтэй асуудлуудыг хамарсан байна.



Он: 2006, Хот: УБ
Хэвлэлийн газар: ШУТИС, ХУСТ
Хуудас: 318
ISBN: 99929-3-103-5

Барилгын төслийн менежмент

Зохиогч: Л.Шагдаррагчаа

Редактор: Б.Батцагаан, Г.Түмэнжаргал, Б.Буриад, В.Мөнхгэрэл

Барилга байгууламжийн төсөл хэрэгжүүлэх ажиллагааны технологийн менежментийн үндсэн асуудлыг тусгасан бөгөөд энэ чиглэлийн төсөл хэрэгжүүлэгч төрийн болон төрийн бус байгууллага, барилга, зураг төсөл хөрөнгө оруулагч пүүс, компанийн төсөл хариуцсан менежер, инженер, эдийн засагч нарт гарын авлага болно.



Он: 2009, Хот: УБ
Хэвлэлийн газар: Дата софт
Хуудас: 356
ISBN: 978-99929-953-0-0

Бетоны технологи 1,2 дэвтэр


Зохиогч: Ч.Дэндэвдорж

Хянан тохиолдуулсан: Д.Оюунбилэг

Барилгын үндсэн материал болох бетоны үйлдвэрлэлд хэрэглэдэг үндсэн түүхий эдийн материалын чанарт тавигдах стандартын шаардлага, бетоны физик механикийн болон технологийн шинж чанарт үнэлгээ өгөх түүнийг жолоодох орчин үеийн онолын үндэстэй гүнзгий танилцуулах зорилготой сурах бичиг юм. Бетоны технологи сурах бичгийг судалснаар төрөл бүрийн бетоны физик-механикийн болон технологийн шинж чанар, бетоны төрөл, найрлага, бэхжилтийн процесс, чанарын шалгалт, бетон зуурмаг ба арматурын эдлэл бэлтгэх, эдлэл хэвлэх, технологийн дамжлагуудын зүгээс бүтээгдэхүүний чанарт үзүүлэх нөлөөллийн талаар бүрэн ойлголт авах болно.



Он: 2008, Хот: УБ
Хэвлэлийн газар: X-Press
Хуудас: 294



Он: 2008, Хот: УБ
Хэвлэлийн газар: ЖКС
printing
Хуудас: 322
ISBN: 978-99929-73-28-5

Чулуулгийн физик бутлалт

Зохиогч: Б.Лайхансүрэн

Редактор: Л.Пүрэв

Чулуулгийн ангилал, уул технологийн өрөмдөгдөх, бутлагдах, элээх, тэслэгдэх шинж ба физик технологийн шинж болох структур, текстур, нягт, нүх сүвшил, ан цавал, чулуулгийн механик, уян харимхай, акустик, термодинамик, цахилгаан соронзон, цацраг идэвхит шинж зэргийн талаар гол үндсэн ойлголтыг өгөх ба чулуулгийг бутлахад зарцуулагдах энергийг тодорхойлох цахилгаан, соронзон бус аргаар бутлах асуудал, ашигт малтмал олборлох геотехнологийн болон физик химийн аргууд, чулуулгийн массивийн хүчдэлийн төлөв, уулын малталтанд үүсэх ачааллын тухай товч өгүүлсэн.

Чулуулгийн физик, бутлалтын практикум

Зохиогч: Б.Лайхансүрэн

Хянан тохиолдуулсан: Л.Пүрэв

Чулуулгийн физик хэсэгт чулуулгийн уул технологийн шинж, бат бэх түүний статистик параметр, уян харимхайн шинж, бутлалтанд зарцуулагдах ажил зэргийг хэрхэн тооцоолохыг авч үзсэн. Мөн чулуулгийн диформаци үүсэх хүчдэл, эрдсийн түүхий эдийг иж бүрэн ашиглах үеийн хүдрийн үнэт зүйлсийг тодорхойлох асуудлыг тусгасан болно.



Он: 2009, Хот: УБ
Хэвлэлийн газар: Арвай
принт
Хуудас: 172
ISBN: 99929-78-37-6

Тэслэгээний ажлын тооцоо

Зохиогч: Б.Лайхансүрэн

Хянан тохиолдуулсан: Л.Пүрэв

Тэслэгээний ажлын параметруудийг орд газрын уул геологи болон уул технологийн нөхцөлийг харгалзан тодорхойлсон үр дүн, мөн материал зарцуулалтын үйлдвэрлэлийн ба төслийн технологийн нормыг үндэслэн тооцоолох асуудлыг тус тус оруулсан байна. Түүнчлэн ил уурхайд өргөн хэрэглэгдэх шпур, цооногийн цэнэгийн арга, гал ба цахилгаанаар өдөөн тэслэх аргын тооцоо, траншей нэвтрэлт, цацалт, шидэлтийн тэслэгээний ажлын тооцоо зэргийг тусгасан байна.



Он: 2009, Хот: УБ
Хэвлэлийн газар: ЖКС printing
Хуудас: 188
ISBN: 978-99929-971-1-7

Уул уурхайн машины ашиглалт засвар

Зохиогч: Ц.Нанзад, Д.Гэрэлт-Од, К.Хавалболат

Гарын авлагад засварын газрын жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, график, ажлын зохион байгуулалт, жигд ажиллагааг жилийн туршид хангах, ачаалал хувиарилах болон засварын байгууллагын тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон талбай, байршлын тооцоог хэрхэн хийх тухай дэлгэрэнгүй тусгасан. Засварын газрын план байгуулах, хэрхэн тэмдэглэх талаар жишээ үзүүлсэн байна.



Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: ШУТИС.
ХҮСТ
Хуудас: 73

Уурхайн машины найдвартай ажиллагааны онолын үндэс

Зохиогч: Ц.Нанзад

Хянан тохиолдуулсан: Д.Гэрэлт-Од

Найдвартай ажиллагааны онолын үндсэн ойлголт, ухагдахуун үзүүлэлтүүд, тэдгээрийн ангилал улмаар хэрхэн тодорхойлох аргуудыг тусгасан болно. Санамсаргүй хэмжигдэхүүний тархалтын хуулиуд, түүнийг тодорхойлох аргуудыг тодорхой жишээн дээр авч үзэж, найдвартай ажиллагааны анхдагч материалд боловсруулалт хийх тухай тусгасан. Тодорхой үе шатуудад уурхайн машин, техникийн найдвартай ажиллагааны түвшинг дээшлүүлэх арга замуудыг авч үзсэн байна.



Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: Амжа
принт
Хуудас: 158

Уул уурхайн машины найдвартай ажиллагааны онолын үндэс

Зохиогч: Ц.Нанзад, К.Хавалболат

Хянан тохиолдуулсан: Д.Гэрэлт-Од

Техникийн системийн найдвартай ажиллагааны онолын үндсэн үзүүлэлт, техникийн системийн бүтцийн хэлбэрүүд, тэдгээрийг хялбарчлах арга болон найдвартай ажиллагааны түвшинг дээшлүүлэх арга замуудыг тодорхой оруулсан болно. Мөн техникийн системийн бүтцийн найдвартай ажиллагааны тооцоог тодорхой жишээн дээр авч үзсэн байна.



Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: ШУТИС. ХҮСТ
Хуудас: 64
ISBN: 99929-51-75-5



Он: 2009, Хот: УБ
Хэвлэлийн газар: Амжа
принт
Хуудас: 176
ISBN: 99929-3-159-0

Уурхайн цахилгаан машин тоног төхөөрөмжийн ашиглалт засвар

Зохиогч: Ц.Нанзад, Ж.Цэвэгмид, К.Хавалболат, Д.Гэрэлт-Од

Хянан тохиолдуулсан: Ж.Цэвэгмид

Цахилгаан машины зарчмын хийцийн үндсэн ангилал, бүтэц, ажиллах зарчим, тэдгээрийн ашиглалтын шинжүүд нөлөөлөх хүчин зүйлийн талаар товч дурьдсан. Цахилгаан машин, тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээний системийн мөн чанар, агуулга, засвар, техникийн үйлчилгээний тоог тодорхойлох аналитик болон график, номограмын аргуудыг тодорхой заасан.



Он: 2009, Хот: УБ
Хэвлэлийн газар: Мөнхийн
үсэг
Хуудас: 526
ISBN: 978-99929-1-661-3

Дулаан дамжуулалтын онол хичээлээр бие даан хийх тооцооны гарын авлага

Зохиогч: Ц.Цэндээхүү

Хянан тохиолдуулсан: Н.Алтансүх, Ш.Цоож, Ц.Энхзул

Энэхүү гарын авлага нь оюутны бие даасан ажиллагааг хөгжүүлэх, дулаан масс солилцооны онолын үндсийг гүнзгий ойлгуулах, практикт хэрэглэх чадвар эзэмшүүлэх зорилготой. Гарын авлагыг ашиглан дулааны масс солилцооны бодлогуудыг бие дааж бодохоос гадна онолын мэдлэгээ бататгах бөгөөд бодлогууд нь тухайн хичээлийн хөтөлбөрийн агуулгыг бүрэн хамарсан болно.



Он: 2009, Хот: УБ
Хэвлэлийн газар: Урлах эрдэм
Хуудас: 318
ISBN: 978-99929-52-20-2

Метал судлал

Зохиогч: Ч.Даваасамбуу

Хянан тохиолдуулсан: Ц.Жамбалсамбуу

Металлын бүтэц, хими-физикийн шинж чанарын тухай товч тодорхойлж, металтай холбогдолтой зарим тулгуур ойлголтуудыг тайлбарласан. Дулааны хүчний төхөөрөмжид хэрэглэдэг гангийн шинж чанар, тэдгээрийг ширээх, гагнах аргууд, зэврэлтээс хамгаалах, илчийн боловсруулалтын тухай зарим ойлголтуудыг тусгасан.

Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт

Зохиогч: Ж.Гэрэлхүү, Д.Очирбат, Г.Чулуут

Барилга байгууламжийг барихад үйлдвэрлэлийг хэрхэн зохион байгуулах онолын үндэс ба практик аргад суралцах, үйлдвэрлэлийг удирдан зохион байгуулах, барилгын үйлдвэрлэлийг зохион байгуулах технологи-зохион байгуулалтын баримт бичиг боловсруулах аргачлал, түүнчлэн барилгын зураг төсөл-эрэл, хайгуулын ажлын арга зүй, барилга дахь чанарын удирдлага болон шинэ бүтээл, ашигтай загвар, материал-техникийн хангалтыг зохион байгуулах зэрэг өргөн хүрээтэй асуудлыг тусгасан.

Хүдрийн далд уурхайн технологи, аэрологи

Зохиогч: Б.Лайхансүрэн
Хянан тохиолдуулсан: Л.Пүрэв

Хүдрийн далд уурхайн технологийн хэсэгт ашигт малтмалын орд газрын уул геологийн нөхцөл, чулуулгийн физик, механикийн шинж чанар, орд газрыг нээх бэлтгэх, олборлох технологийн профес, ашиглалтын систем, уулын даралт, хүдрийн хаягдал, бохирдол, ашигт малтмал олборлох тусгай арга зэргийг уул уурхайн практик үйлдвэрлэлийн ололтод тулгуурлан авч үзсэн. Мөн олборлолтын мөргөцөг дэх үйлдвэрлэлийн процессын механикжуулалт, "Монголпросцветмет" нэгдлийн харьяа адагийн хайлуур жоншны ордыг далд аргаар олборлох асуудал, хүдэр олборлох техник, технологийн дэвшил зэрэг шинэ соргог асуудлыг тусгасан байна.

История монгольской архитектуры

Зохиогч: В.Н.Ткачев

Энэхүү номонд нүүдлийн ба суурин соёл иргэншлийн хоорондын харилцан хамаарал нэг туйлширсан систем болсон, Төв Азид байдаг орчин үеийн Монголын архитектурын үүслийн талаар бичсэн байна. Нүүдлийн архитектурын морфогенезд цаг уур, нийгмийн, уран сайхны хүчин зүйлүүд нөлөөлсөн болохыг уншина. Цаг уурын таатай нөхцөлд үүссэн адаптаци нь уламжлалыг орон зайн болон зохион бүтээлтийн, загварлаг шинжтэй болгож Монголын орчин үеийн үндэсний архитектурыг үүсгэж буй болгосон тухай уншиж болно.



Он: 2009, Хот: УБ
Хэвлэлийн газар: Согоо нуур
Хуудас: 268
ISBN: 978-99929-977-5-3



Он: 2009, Хот: УБ
Хэвлэлийн газар: Арвай принт
Хуудас: 254
ISBN: 978-99929-812-2-9



Он: 2009, Хот: Москва
Хэвлэлийн газар: АСВ
хэвлэлийн газар
Хуудас: 288
ISBN: 978-5-9303-664-3

Шинжлэх Ухаан Технологийн төв номын сангийн шинэ номын мэдээ



Он: 2007, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: Адмон
Хуудас: 214
ISBN: 978-99929-58-23-5

Монголын уран барилгын түүх

Зохиогч: Б.Даажав, Р.Баяр
Хянан тохиолдуулсан: Д.Хайсамбуу
Дэд гарчиг: Их хүрээ
Цуврал: Хоёрдугаар дэвтрийн II хавсралт

Орчин үеийн тулгамдсан асуудлууд болох хот үүсгэх арга, хотын газар нутгийг бүсчлэх, газар өмчлөх, эзэмших, түрээслэх болон газар үнэлэх талаар хэрэгжүүлж байсан уламжлал, хүн амын бодлогыг хот зохион байгуулах арга ухаандаа хэрхэн тусгаж байсныг авч үзэж болно.



Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: Соёмбо принт
Хуудас: 354
ISBN: 9-290520-091546

Модон ба хуванцар бүтээц

Зохиогч: Г.Базар, Я.Дүйнхэржав
Хянан тохиолдуулсан: П.Отгонбаяр, М.Оюунчимэг

Модон ба хуванцар бүтээцийн тооцооны онол, туршлагын асуудлыг дэлгэрэнгүй бичсэнээс гадна зарим өргөн хэрэглэгддэг бүтээцийн тооцооны жишээ бодож оруулсан болно.



Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: Арвай принт
Хуудас: 359
ISBN: 99929-71-22-3

Уул уурхайн үйлдвэрийн техник-эдийн засгийн шинжилгээ

Зохиогч: Ж.Бямба-Юу, С.Цэрэндорж
Хянан тохиолдуулсан: П.Очирбат

Зах зээлийн харилцаа бүрэлдэн төлөвшиж байгаа уул уурхайн үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд шинжилгээг бүх талаас хийх онол арга зүй, практик аргачлалуудыг багтаасан, хэвшмэл хэлбэрүүдийг шинэчлэх системийн хандлагын агуулгатай. Уул уурхайн үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, борлуулалт, зээлийн процессын орон зай, цаг хугацааны горизонтальд санамсаргүйн хүчин зүйлүүдээс технологийн горимын параметрууд, норм, норматив, стандарт, ахиуц хэмжээсүүдэд нөлөөлөх эерэг, сөрөг шалтгаан үр дагаварыг техник-эдийн засгийн аспектиудаар шинжлэх зарчмуудад онцгой анхаарсан.

Үйлдвэрийн эдийн засаг

Зохиогч: Т.Нарантуяа, Ш.Халтар

Бизнесийн зохион байгуулалтын орчин үеийн хэлбэрүүд, үйлдвэрлэлийн дотоод удирдлага, зохион байгуулалт, бизнесийн удирдлага, үйлдвэрийн газрын маркетингийн үйл ажиллагаа, үйлдвэрийн эдийн засаг, хөрөнгө оруулалт, санхүү, татварын тогтолцоо зэрэг үйлдвэрийн газрын оршин тогтнох чадварыг хангах орчин үеийн эдийн засгийн арга механизмуудын талаар товч, тодорхой ойлголт авна.



Он: 2009, **Хот:** УБ
Хуудас: 227
ISBN: 978-99929-959-1-2

Мэргэжлийн гэрэл зураг засвар PHOTOSHOP

Зохиогч: Л.Давасүрэн

Дижитал гэрэл зураг авах онолын үндэс, дижитал камерын нууц, давуу тал, сканерыг ашиглах, зураг засах график дизайн хийх аргачлал зэрэг photoshop програмын давуу талыг хэрхэн ашиглах талаар дэлгэрэнгүй бичсэн байна.



Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: Өатхийморь
Хуудас: 423
ISBN: 99962-10-01-1

Компьютерийн хэрэглээ


Зохиогч: Ц.Батцэцэг, П.Алтанцэцэг

Редактор: Б.Орхонтуул

Сурах бичиг нь үндсэн 4 бүлэгт хуваан бичигдсэн ба модуль 1: мэдээллийн технологийн үндсэн ойлголт, модуль 2: компьютер ашиглалт болон файл зохион байгуулалт, модуль 3: MS Word програм, модуль 4: Excel програмын сэдэв бүрийг дасгал хичээлүүдтэй дэлгэрэнгүй тусгасан.



Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: Содпресс
Хуудас: 224
ISBN: 978-99929-54-94




Он: 2009, Хот: УБ
Хэвлэлийн газар: ШУТИС
ХҮСТ
Хуудас: 131
ISBN: 978-99929-51-89-3

Мэргэжлийн удиртгал

Зохиогч: Б.Энхжаргал, Г.Нандин
Редактор: Д.Пүрэвдаш

Эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн мэргэжлээр эхлэн суралцагч, эрүүл мэндийн салбарын инженер техникийн ажилтан, эмч сувилагч нарт зориулагдсан.



Он: 2008, Хот: УБ
Хэвлэлийн газар: Хөх
судар принтинг
Хуудас: 212

Хөдөлмөрийн эрүүл ахуйн гарын авлага

Зохиогч: Ц.Тажаа, Л.Оюунтогос
Хянан тохиолдуулсан: С.Нямзагд

Ажиллагсад ба хөдөлмөрийн хамт олны эрүүл мэндийг хамгаалах, ажиллах чадварыг хадгалах ба дээшлүүлэхэд чиглэгдсэн ариун цэвэр-эрүүл ахуйн ба эмнэлэг-урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийн талаар, норм, норматив, стандартыг оруулсан.



Он: 2008, Хот: УБ
Хэвлэлийн газар: Хөх
судар принтинг
Хуудас: 90

Хөдөлмөрийн физиологи

Зохиогч: Ц.Тажаа
Хянан тохиолдуулсан: С.Мөнхбаярлах

Биеийн ба оюуны хөдөлмөрийн физиологийн зүй тогтол, орчин үеийн үйлдвэрлэлийн нөхцөлд хүний ажиллах чадварын хэм хэмжээг тодорхойлогч физиологийн механизм, үйлдвэрлэлийн ажиллагааны үе дэх хөдөлмөрийн хүнд хөнгөний зэрэгт үнэлэх зэрэг асуудлуудыг тусгасан.

Цементийн химийн лабораторийн ажлын удирдамж

Зохиогч: Ж.Бадамсүрэн, Р.Санжаасүрэн
Хянан тохиолдуулсан: Р.Санжаасүрэн

I бүлэгт цементийн үйлдвэрлэлийн түүхий эдийн химийн найрлагыг сүүлийн үед аналитик химид хүч түрэн орж ирж байгаа нийлмэл урвалжийн аргаар тогтоох аргачлалуудыг оруулсан. II бүлэгт цементийн түүхий эд бэлтгэх тооцоо, нам температурт чулуунцар синтезлэх, цементийн физик маханик туршилтууд болон цементийн фазын найрлагыг судлах физик-химийн аргуудыг бичсэн.



Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: МУИС хэвлэх
Хуудас: 131
ISBN: 978-99929-53-89-6

Арьс шир, үслэгийн үйлдвэрлэлийн экологийн асуудал

Зохиогч: С.Дашбал, А.Гантөмөр
Редактор: Д.Урнаа

1-р бүлэгт зүй тогтлоороо явагддаг байгалийн эргэлтийн тухай ойлголт, шинжлэх ухаан технологийн үсрэнгүй хөгжлийн өнөө үед байгалийн нөөцийг ашигласнаас гарч байгаа хор хөнөөл нь эргээд бидний хүрээлэн байгаа орчинд сөргөөр нөлөөлж аюулгүй амьдралын үнэ цэнийг алдагдуулах байдалд хүрээд байгааг харуулахыг хичээсэн болно.



Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: Судар мөнх
Хуудас: 166, **ISBN:** 978-99962-1-561-7

Ургамлын физиологи

Зохиогч: Ц.Цэндээхүү
Хянан тохиолдуулсан: Н.Алтансүх, Ш.Цоож, Ц.Энхзул

Ургамлын амьдралын дотоод олон талт үзэгдлийн тухай орчин үеийн үндсэн мэдлэг, онол практикийн ач холбогдолтой. Ургамлын эсийн бүтэц, үүрэг ба үйл ажиллагааны зохицуулга, уургийн бионийлэгжил, удамшлын код, ургамалд ус шингэж зарцуулагдах горим фотосинтез, амьсгал, эрдэс бодисын хооллолт, өсөлт ба хөгжилт, ургамлын хөдөлгөөн, гормон цэцэглэлт үр жимс боловсруулах, усалгааны тухай дэлгэрэнгүй оруулсан.



Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: Мөнхийн үсэг
Хуудас: 526
ISBN: 978-99929-1-661-3



Он: 2009, Хот: УБ
Хуудас: 509
ISBN: 978-99929-964-2-0

Галт микробиологи

Зохиогч: Л.Галт
Хянан тохиолдуулсан: Л.Цэрэнням

Амьдралын үүсэл ба амьд биесийн дунд бичил биетний эзлэх байр суурь, бичил биетний эсийн бүтэц, зохион байгуулалт, хооллолт ба бодисын солилцоо, микробын өсөлт хөгжилт, бичил биетний молекул биологийн үндэс, микробын гинетик, үйлдвэрлэлийн микробиологи, бичил биетэн дээд ургамал хоёрын харилцан шүтэлцээ, дархлаа судлал ... гэсэн 19 бүлэгт хуваан оруулсан байна.



Он: 2009, Хот: УБ
Хэвлэлийн газар: МУИС
хэвлэх үйлдвэр
Хуудас: 389

Органик хими стереохими

Зохиогч: Д.Жамбал, Ж.Ирэхжаргал, Ж.Ирэхбаяр

Органик химий үндсэн асуудлын нэг болох орон зайн ба электрон эффект, урвалын механизмын талаар зохих түвшинд аль болохоор явцуу биш нийтлэг, талыг нь түлхүү анхаарч багцлан зохиохыг хичээсэн болно.



Хэвлэлийн газар: Тоонот
принт
Хуудас: 502
ISBN: 978-99929-50-05-6

Органик хими

Зохиогч: Б.Бямбагар
Хянан тохиолдуулсан: М.Наранцэцэг

Органик бодисын химийн ба физикийн шинж чанар нь тэдгээрийн орон зайн байгуулалт, атомуудын харилцан нөлөөллөөс ихээхэн хамаардгийг харгалзан стереоизомер буюу энантиомерыг дүрслэх аргууд, тэдгээрийн D, L ба R, S нэршил, абсолют конфигурацийг тодорхойлох арга, динамик стереохими болон электроны эффект, резонанс, урвалын төрлүүд, тэдгээрийн механизм, явагдах чиглэлийн тухай ойлголтуудыг түлхүү оруулсан болно.

Аналитик химийн бодлогын хураамж

Зохиогч: Д.Бурмаа, Ж.Пүрэв, Г.Хишигт, А.Ганпүрэв

Аналитик химийн 2 том хэсэг болох чанарын ба тооны анализын гол сэдэвүүдийг онолын товч тайлбартай, бодлого бодох аргыг жишээ бодлоготойгоор оруулсан болно.



Он: 2009, **Хот:** УБ
Хуудас: 114

Ерөнхий химийн бодлого дасгалын хураамж

Зохиогч: Б.Бямбагар
Хянан тохиолдуулсан: П.Мөнхбаатар

Химийн үндсэн ойлголт ба гол хуулиуд, органик бус нэгдлийн ангилал, нэршил, химийн томъёо, тэгшилгэлээр хийх тооцоо, атомын бүтэц, химийн холбоо ба молекулын бүтэц, химийн процессийн энерги ба чиглэл, химийн урвалын хурд ба тэнцвэр, уусмал түүний концентрацийг онол, исэлдэх-ангигжих урвал, электролиз гэсэн үндсэн бүлэг сэдвүүдийг багтаан бичигдсэн байна.



Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: Поонот принт
Хуудас: 272
ISBN: 978-99929-839-0-6

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСАГ, МАРКЕТИНГ, МЕНЕЖМЕНТ

Монгол улсын иргэний ирх зүй

Зохиогч: О.Жамбалдорж, Ж.Амарсанаа, Ж.Ариунзаяа

Хуулийн их, дээд сургуулийн сурах бичгийн үндсэн зориулалттай бөгөөд зах зээлийн харилцааны амин гол асуудлуудыг тусгасан тул хууль зүйн алба, шүүх прокурор, төрийн байгууллагын ажилтан, бизнес эрхлэгчдэд чухал гарын авлага болно.



Он: 2006, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: Адмон
Хуудас: 214
Цуврал: II дэвтэр
ISBN: 99929-0-008-3




Он: 2008, Хот: УБ
Хэвлэлийн газар: Адмон
Хуудас: 115
ISBN: 99929-58-08-5

Төрийн секторын эдийн засаг

Зохиогч: Ж.Стиглиц
Хянан тохиолдуулсан: Б.Намхайжанцан
Орчуулагч: Ц.Нарангэрэл

Төрийн секторын эдийн засаг 1, 2 номонд Төрийн секторын эдийн засгийн онолыг АНУ-ын жишээн дээр цэгцтэй, ойлгомжтой томъёолсон бөгөөд улс орны өмнө тулгамдаж буй асуудлын шийдэл, хөгжлийн гарцыг шинээр харж практик амьдралд барууны шинжлэх ухааныг хэрхэн нэвтрүүлэх аргыг тусгасан нь оюутан, багш, судлаачдад тус төхөм болно.




Он: 2006, Хот: УБ
Хэвлэлийн газар:
Интерпресс
Хуудас: 282

Улс төр

Зохиогч: Аристотель
Орчуулагч: Б.Даш-Ёндон

Төр улсын үндэс, эд эсүүд, эдийн засаг, төрийн байгууламжийн төслүүд холбогдсон онолын үндсэн асуудал, дүрсүүд, хамгийн шилдэг улс төр, түүний хүмүүжил гэх мэт бүлгүүдэд хуваан авч үзсэн.



Он: 2008, Хот: УБ
Хэвлэлийн газар:
Цоморлиг хэвлэл
Хуудас: 221

Дэлхийн эдийн засаг

Зохиогч: Х.Эрдэнэчулуун
Хянан тохиолдуулсан: Ч.Улаан, Б.Бямбаа,
Ю.Оюунжаргал

Дэлхийн эдийн засаг, дэлхийн аж ахуйн систем, олон улсын эдийн засгийн харилцаа аж ахуйн системийн бүрэлдэхүүн хэсэг, хөгжлийн үе шат, олон улсын худалдааны хүчин зүйлс, олон улсын худалдааны уламжлалт ба орчин үеийн онолууд, хүчин зүйлсийн шилжилт хөдөлгөөн, соёл иргэншлийн онолуудын талаархи үндсэн ойлголтуудыг авна.

Хүний нөөцийн менежмент

Зохиогч: Ц.Цэцэгмаа

Редактор: Х.Пүрэвдагва

Мэргэжлийн нэр томъёоны нэр агуулгыг нэг мөр болгоход хувь нэмэр оруулах зорилгоор Хүний нөөцийн менежментийн үндсэн нэр томъёоны тайлбар толь нэртэй хэсгийг сурах бичгийн төгсгөлд шинээр оруулж өгсөн. Энд мэргэжлийн 250 гаруй нэр томъёог монгол-англи-орос хэлээр илэрхийлж агуулгыг монгол хэлээр тайлбарласан болно.



Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: Голден ай принтинг
Хуудас: 487
ISBN: 978-99962-75-62-8

Хүний нөөцийн удирдлага

Эмхэтгэн орчуулсан: С.Давааням, С.Дулмаа

Редактор: Д.Болдбаатар, Л.Оюунцэцэг

Удирдахуйн ухааны хөгжлийн орчин үеийн чиг хандлагыг тодорхойлж байгаа инновацийн удирдлага болон хүний нөөцийг удирдахад түгээмэл тохиолддог эрх мэдлийн шилжүүлэлт, ажилтныг оновчтой сонгон авах, шинэ ажилтныг дадлагажуулах, төвөгтэй ажилтантай ажиллах зэрэг асуудлуудыг шийдвэрлэхэд онцгой анхаарсан байна.



Он: 2009, **Хот:** УБ
Хуудас: 166
ISBN: 978-99962-4-412-9

Үндсэн хуулийн мэдлэг

Зохиогч: Б.Чимэд

Редактор: Д.Солонго

Үндсэн хууль, Үндсэн хуулийн үзэл баримтлал, Үндсэн хуулийн эрх зүйн талаар цогц мэдээлэл оруулсан байна.



Он: 2008, **Хот:** УБ
Хуудас: 495
ISBN: 978-99929-0-527-1



Он: 2006, Хот: УБ
Хэвлэлийн газар: ШУТИС.
ХҮСТ
Хуудас: 166
ISBN: 99929-3-050-0

Бизнесийн харилцаа

Зохиогч: Ц.Энхбаатар, Ш.Даваахүү
Хянан тохиолдуулсан: Х.Нялхай

Гарын авлагад бизнесийн харилцаанд тохиолдох үйл ажиллагааны бүхий л талуудыг эх орны ба гадаад орнуудын жишээн дээр тулгуурлан ойлгомжтойгоор тусгасан байна.



Он: 2009, Хот: УБ
Хэвлэлийн газар:
Стартлайн
Хуудас: 128
ISBN: 978-99962-847-4-0

Маркетингийн тест

Зохиогч: Б.Ганшагай, С.Сайн-Оды
Редактор: Ц.Батсүх

Энэхүү бүтээл нь маркетингийн үндсэн ойлголт, бизнесийн орчин, маркетингийн стратеги, маркетингийн хөтөлбөр тэдгээрийн хүрээнд гардаг шийдвэрүүд, төлөвлөх арга замуудтай танилцуулахаас гадна маркетингийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх, өөрийгөө сорих боломжийг олгож байна.



Он: 2009, Хот: УБ
Хэвлэлийн газар:
Улаанбаатар принт
Хуудас: 250
ISBN: 978-99962-4-293-2

Микро эдийн засгийн ухаан

Зохиогч: А.Бакей
Редактор: Б.Пүрэв, Л.Нямбат

Сурах бичгийн эхний хэсэг болох микро эдийн засгийн хэсэг дээр засварын түвшний микро эдийн засгийн онолын үндсэн асуудлыг нэмж, анхан болон дунд шатны төвшнийх болгосон. Мөн гадаад хэл дээрх мэргэжлийн ном, сурах бичиг ашиглахад уншигчдад тус дөхөм болох үүднээс хамгийн түгээмэл хэрэглэгддэг 300 гаруй нэр томъёо, үг хэллэгийн монгол, орос, англи, хэлний толь, зарим товчилсон үгийн тайлбар болон эдийн засгийн ухааны хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан эрдэмтдийн тухай мэдээллийг нэмж тусгасан.

Үйлдвэрийн эдийн засаг

Зохиогч: Т.Нарантуяа, Ш.Халтар

Бизнесийн зохион байгуулалтын орчин үеийн хэлбэрүүд, үйлдвэрлэлийн дотоод удирдлага, зохион байгуулалт, бизнесийн удирдлага, үйлдвэрийн газрын маркетингийн үйл ажиллагаа, үйлдвэрийн эдийн засаг, хөрөнгө оруулалт, санхүү, татварын тогтолцоо зэрэг үйлдвэрийн газрын оршин тогтнох чадварыг хангах орчин үеийн эдийн засгийн арга механизмуудын талаар товч, тодорхой ойлголт авна.

Он: 2009, **Хот:** УБ
Хуудас: 227
ISBN: 978-99929-959-1-2



ХЭЛ, ХЭЛ ШИНЖЛЭЛ

Хэл шинжлэлийн утгазүй

Зохиогч: Э.Равдан

Редактор: С.Мөөмөө, Г.Лувсан, Д.Цэрэнпил

Номонд орчин цагийн хэл шинжлэлийн асуудлыг тусгасан болно.

Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: Адмон
Хуудас: 224
ISBN: 978-99962-2-450-0



Үг, өгүүлбэрийн амьдрал араншин эрчим энерги, соёл хэрэглээ

Зохиогч: Б.Пүрэв-Очир

Редактор: Д.Нямаа

Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: Мөнхийн үсэг групп
Хуудас: 292
ISBN: 978-99962-1-694-X





Он: 2003, Хот: Москва
Хэвлэлийн газар: Этносфера хэвлэлийн газар
Хуудас: 150
ISBN: 5-93125-010-7

Уроки русской речи

Зохиогч: О.Н.Каленкова

Москвагийн институтийн олон улсын боловсролын тэнхимээс гаргасан нээлттэй боловсролын гадаадын цагаачдын гэр бүлийн 6-7 насны хүүхдүүдэд арга зүйн программын дагуу энэхүү номыг гаргасан байна. Энэ ном нь гадаад хүмүүст орос хэл заадаг багш нарт зориулагдсан байна. Энэхүү программ нь дунд сургуулийн 1-р ангид орос хэл эзэмшээгүй орж ирж байгаа энэ насны хүүхдүүдийн психологийн онцлогийг харгалзан тооцон гаргасан.



Он: 2009, Хот: УБ
Хэвлэлийн газар: Адмон
Хуудас: 190

Пособие по русскому языку

Зохиогч: А.Навчаа

Редактор: Т.Батбаяр

Орчуулагч: Н.Пүрэвдавга

Дэд гарчиг: Для студентов изучающих экономику и бизнес

Энэхүү гарын авлага нь эдийн засгийн мэргэжлээр сурч байгаа оюутнуудад зориулагдсан орос хэлний хичээлд ашиглагдана. Энэ ном нь үндсэн болон туслах гэсэн 2 хэсэгтэй. Үндсэн хэсэгт эдийн засгийн талаар бичсэн текстүүдийг оруулжээ. Туслах хэсэгт тийн ялгалууд, газрын нэр, г.м. дүрмүүдийг оруулсан байна. Ном нь оюутнуудад эдийн засаг болон бизнесийн сэдвийг эзэмшихэд чиглэгдсэн.



Он: 2009, Хот: УБ
Хуудас: 182
ISBN: 978-99929-51-55-9

English for engineering in medicine

Зохиогч: B.Enkhgargal, Ch.Solongo, G.Nandin

Хянан тохиолдуулсан: J.Dashdorj, S.Dugarmaa

Эмнэлэгийн тоног төхөөрөмжийн чиглэлээр суралцдаг оюутнуудад зориулагдсан ба Мэргэжлийн үг хэллэгийг агуулснаараа хэрэглэхэд дөхөмтэй болсон.

Живая душа русского мира

Дэд гарчиг: Орос хэл заадаг сургуулийн захирлуудын олон улсын хурлын эмхтгэл

Эмхэтгэл нь гадаадад орос хэлийг заадаг орчин үеийн чухал асуудлуудын тусгасан мэдээлэл-лавлагааны шинж чанарыг тусгасан байна. Энэ цуглуулгад Орос ертөнцийн агуу их орон зайд оросын соёл иргэншилд үүрэг гүйцэтгэж буй гадаадын орос хэл заадаг сургуулиудын ажлын тухай материалууд оржээ. Эмхэтгэлийн хуудаснуудад орос хэлийг цаашид хөгжүүлэхэд зайлшгүй хэрэгтэй олон тооны багш нарын нэр, хэрэгжүүлж байгаа туршлагаудын тухай оржээ.



Он: 2004, Хот: Москва
Хэвлэлийн газар: Этносфера хэвлэлийн газар
Хуудас: 191
ISBN: 5-93125-020-4

Русский язык без границ

Зохиогч: Ц.Тажаа, Л.Оюунтогос

Хянан тохиолдуулсан: С.Нямзагд

Дэд гарчиг: Орос хэл заадаг сургуулиудын захирлуудын олон улсын хурлын материалуудын эмхэтгэл

Эмхэтгэлд сургуулийн орос хэлний багш нарт практик болон арга зүйн туслалцаа өгөхөд чиглэгдсэн, Оросын боловсролд туслалцаа үзүүлэх, гадаадын уламжлалт болон шинэ орон зайд орос хэл ба орос соёлыг хамгаалах асуудлуудыг тусгасан байна. Гадаадын сургуулиудын орос хэл заадаг багш нарын тухай мэдээлэл, олон улсын багш нарын холбооны тухай материал ба баримтуудыг агуулжээ. Орос хэл сурч буй оюутнууд, магистрантууд, мэргэжилтнүүд, мөн өөрийн боловсролоо дээшлүүлж буй хүмүүст зориулав.




Он: 2005, Хот: Москва
Хэвлэлийн газар: Хөх судар
принтинг
Хуудас: 358
ISBN: 5-93125-026-3


Cambridge Preparation for the TOEFL Test / Internet – Based Test

Зохиогч: Jolene Gear, Robert Gear

Англи хэлний түвшинг /компьютер ашиглан/ тогтоох шалгалтанд бэлтгэх уг ном нь /8 ширхэг CD-тэй/ TOEFL шалгалтанд тавигдаж байгаа асуултанд амжилттай хариулахад зайлшгүй шаардлагатай дадал чадваруудыг бий болгоход тусална. Түүнчлэн TOEFL-н шалгалтын журамтай болон шалгалтыг өгөх арга барилтай нарийн танилцуулах бөгөөд таны шалгалтанд авах оноог ахиулахад дүрмийн болон дасгалын хэсэг, өөрийгөө шалгах 7 янзын тестүүд нь ихээхэн тустай.



Он: 2006
Хот: USA
Хуудас: 661
ISBN: 978-0-521-75584-9



Он: 2010, Хот: УБ
Хэвлэлийн газар: ШУТИС
ХУСТ
Хуудас: 220
ISBN: 978-99962-813-0-3

Petroleum English

Зохиогч: S.Sereenen, J.Tseveenjav, Ts.Altantsetseg, P.Zoltongoo

Редактор: Т.Батбаяр

Орчуулагч: Н.Пүрэвдавга

Газрын тосны мэргэжилтэн бэлтгээд цөөнгүй хэдэн жил болсон ба газрын тосны мэргэжилтнүүдэд англи хэл үзэх зайлшгүй хэрэгтэй байна. Мэргэжлийн газрын тосны толь бичиг хэвлэгдэн гарсан боловч мэргэжлийн нэр томъёо, үг хэллэг, дүрмүүдийг агуулсан. Геологийн мэргэжлийн англи номыг гаргаж байна. Энэ ном нь геологийн чиглэлээр сурч байгаа оюутнууд, ажиллагсад болон геологийг сонирхож буй бүх хүмүүст зориулагдсан байна.



The new global English-japanese dictionary

Англи хэлнээс Япон хэлрүү орчуулсан толь бичиг

Он: 1994
Хэвлэлийн газар: Sanseido
Хуудас: 2093
ISBN: 385-10747-5

ТАНИН МЭДЭХҮЙ, БОЛОВСРОЛ



Цаст алтайн чуулган

Зохиогч: Б.Монголхүү

Редактор: А.Бакей

Хоёр бүлэгт хуваан бичсэн бөгөөд тэргүүн дэвтэрт нь түүхэн өгүүлэмж голлосон тул "Эрт эдүгээгийн хураангуй өчил" гэж нэрлэсэн байна. Дэд дэвтэрт дан хувь хүмүүсийн тухай өгүүлсэн болохоор "Ойрынхон ба холынхон" гэж нэрлэсэн болно.

Он: 2009, Хот: УБ
Хэвлэлийн газар: Ган принт
Хуудас: 981
ISBN: 99962-62-34-8

Он цагийн дуртгал

Зохиогч: Ж.Дашдаваа
Хянан тохиолдуулсан: Ч.Авдай

Нэгдүгээр хэсэгт хүн төрөлхтөн үүсч бий болсон цагаасаа байгалийн зэрлэг жимс, ургамлаар хооллох явцдаа үр тариагаар гурил үйлдвэрлэж хүнсэндээ нэмэрлэдэг байсан бол гурилын хэрэгцээ улам өссөөр түүнийг хэрэглэдэггүй хүн гэж үгүй болсон тухай, Хоёрдугаар хэсэгт монгол орны эртний газар тариалан эрхлэлт, орчин үеийн газар тариалан гурилын үйлдвэрлэлийн суурь тавигдсан үе, Гуравдугаар бүлэгт 1921 оноос ардын хувьсгалаас хойш атар газар эзэмших анхны аян эхлэх хүртэлх үеийг хамарч, Дөрөвдүгээр бүлэгт газар тариалан гурилын үйлдвэрийн 1959-1999 оны хөгжлийн үеийг авч үзсэн. Тавдугаар бүлэгт Монгол улын Засгийн газраас 2009 онд атрын гуравдугаар аяныг санаачлан зохион байгуулсан нь төрөөс баримтлах хүнсний бодлогыг хэрэгжүүлэхэд томоохон үүрэг гүйцэтгэх болсон тухай оруулсан байна.



Он: 2009, Хот: УБ
Хэвлэлийн газар: Жиком
пресс
Хуудас: 334

Нангиадын сонгодог утга соёлын товчоон

Зохиогч: Я.Ганбаатар
Редактор: Ц.Базаррагчаа, Д.Бадмаанямбу

Хятадын эртний уран зохиолын дээжээс түүвэрлэн оруулсан.

Он: 2006, Хот: УБ
Хэвлэлийн газар: Адмон
Хуудас: 476
ISBN: 99929-0-760-9



Нангиадын сонгодог утга соёлын товчоон:

Зохиогч: Я.Ганбаатар
Редактор: Г.Мэнд-Оёо, Д.Бадмаанямбу
Дэд гарчиг: Таван хэлний орчуулгыг зэрэгцүүлэхүй

Хятадын сонгодогт яруу найргийг таван хэлнээ харьцуулан үзэх боломжийг олгож байгаа хүн төрөлхтөний орчуулгын өв сан баян байгаагийн тод гэрч мөн юм хэмээн тэмдэглэсэн байна.

Он: 2006, Хот: УБ
Хуудас: 319

